

**06 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ**  
**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд Сүхбаатар аймгийн сонгогчид 81,7 хувийн ирцтэйгээр саналаа өгчээ. Сонгогчдын нэрсийн жагсаалтад 40731 хүн бүртгэгдсэний 33063 сонгогч саналаа өгсөн байна. Үүнийг насны ангиллаар авч үзвэл 18-25 насны 5356, 26-40 насны 11888, 41-45 насны 9782, 56-аас дээш насны 6037 хүн саналаа өгч, 26-45 хүртэлх насны сонгогчид хамгийн идэвхтэй оролцжээ.

УИХ-ын сонгуулийн 12 дугаар тойрог Сүхбаатар аймагт зургаан нам эвслээс 10 нэр дэвшигч өрсөлдсөнөөс олонхийн саналаар АН-аас нэр дэвшигч Ж.Батсуурь, Н.Ганибал нар ялалт байгуулж УИХ-ын гишүүдээнээр сонгогдлоо.

**а. ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журмын дагуу 2019 оны ИТХ-ын үйл ажиллагаагаараа тэргүүлсэн Баруун-Урт, Уулбаян, Түвшинширээ сумд болон тусгай байр эзэлсэн Халзан, Онгон сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт шагналыг гардууллаа.

Монгол адууны өв соёлын төв Сүхбаатар аймгийн өнгө төрх болсон гадаад дотоодын жуулчдын сонирхлыг татах өвөрмөц шийдэл бүхий баримлаар дамжуулан иргэдэд урлагийн боловсрол олгох, хотын соёл бахархлыг түгээх сурталчлах зорилгоор Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын тамгын газартай хамтран хөшөөний барималын загвар зохион бүтээх уралдааныг зарласан бөгөөд Д.Анхбаярын "Салхин хүлэг" хэмээх бүтээлийг шалгаруулсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал хуралдаж Егүзэр хутагт Ж.Галсандашын мэндэлсний 150 жилийн ойг зохион байгуулах, Эрдэнэцагаан сумын иргэний өргөдлийг хэлэлцэх, Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг "Ханан фитнес" ХХК-ийн санал хүсэлт, Сүм хийдүүдэд зөвшөөрөл олгох, ҮАБЗ-ийг мэдээллээр хангах ажлын хэсгийг шинэчлэн байгуулах, "Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийн удирдах дэд хороог байгуулах, Орон нутгийн өмчийн газрын асуудлууд, Цагдаагийн байгууллагын танилцуулга мэдээлэл, Уул уурхайн хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, авах арга хэмжээний тухай асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэрийг гарган ажиллалаа.

Мал сүргийн чанар үр ашгийг сайжруулах, бэлчээр нутгаа зүй зохистой ашиглах талаар аймаг орон нутгаас боловсруулсан журамд заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж буй Сүхбаатар сумын 5-р багийн малчин О.Баасанхүүг Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит "Мөнгөн унага" цомын эзнээр өргөмжилж, шагналыг гардууллаа.

**б. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулагдахгүй байгаа бөгөөд халдвар хамгааллын нарийн дэглэм горимыг баримталсаны үндсэн дээр 2019 оны үйл ажиллагааны хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр нь эхний байр эзлэсэн Мөнххаан, Халзан, байранд Наран сумдад шагналыг нь гардууллаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/69 дүгээр захирамж, холбогдох журмын дагуу 2019 онд боловсрол, спортын салбарт өндөр амжилт үзүүлсэн байгууллага, хамт олон, сурагч, тамирчид, дасгалжуулагч нарт аймгийн Засаг даргын 2020 оны А/340 дүгээр захирамжаар 30.5 сая төгрөгийн мөнгөн шагнал олголоо.

Аймгийн Онцгой комисс болон ЗДТГ-аас Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, цагдаагийн байгууллагын алба хаагчид төдийгүй иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Автомашины хөдөлгөөнийг хязгаарлах замын хаалт 110 ширхэг, явган хүний хөдөлгөөнийг хязгаарлах төмөр хаалт, 56 ширхэг дохиур мод, цагдаагийн хантааз, авто замын зөөврийн тэмдэг тэмдэглэгээ зэрэг 15.0 сая төгрөгийн өртөг бүхий эд зүйлсийг олгосон байна.

Ардын хувьсгалын 99, Сүхбаатар аймаг байгуулагдсаны 78 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг аймаг, сумдын хэмжээнд нээлттэй зохион байгуулах тухай аймгийн Засаг

даргын 2020 оны А/38 дугаар захирамж батлагдаж, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэм, эрүүл ахуйг хангуулж ажиллахыг сумд болон холбогдох мэргэжлийн байгууллагад үүрэг болголоо.

**Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлээд байна.

Сум, байгууллагын 2020 оны үйл ажиллагааны хагас жилийн тайлан авах албан бичиг арга зүйг хүргүүлэн, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаварын түүврийн хамтаар цахим групп болон Sukhbaatar.mn вэбсайт-д байршуулж мэдээлсэн.

2019 оны хяналт шинжилгээ, үнэлгээний мөрөөр зөвлөмж боловсруулан агентлаг, байгууллага, сумдад хүргүүлсэн.

#### **Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

2020 оны 6 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 20,297,4 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 3952,4 сая төгрөгийн орлого орж нийт 24249,8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 6 сарын байдлаар Улсын төсөвт 1449,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 1232,6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 85.04 хувиар, Орон нутгийн төсөвт 4995,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 4714,0 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 94,4 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 2931,1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 24351,2 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

ОНХС-ийн орлогын шилжүүлэг /эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр/ төлөвлөгөө 5810803,7 мян.төгрөг, гүйцэтгэлээр 3291389,8 мян.төгрөг. Үүнээс 2036106,9 мян.төгрөг нь Төсвийн тухай хуулийн 60.2.6, 60.2.7 дэх эх үүсвэр болох ашиглалт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл болон мега төслийн АМНАТ төлбөр болно. Үүнийг холбогдох журмын дагуу хуваарилан сумдад 1283522,7 мянган төгрөг хуваарилсан.Сүхбаатар, Эрдэнэцагаан сумд уул уурхайн ашиглалт явуулж буй компаниуд олонтой учир ахиу хуваарилагдсан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын гүйцэтгэл 846963,0 мян.төгрөг, удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 344841,7 мян.төгрөг, автозамын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлд 87500,0 мян.төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй ажлуудын Худалдан авах ажиллагааны мэдээлэл, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн явцын мэдээллийг тухай бүр төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn программд шивж оруулж байна.

Мөн төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх сургалтанд онлайнаар хамрагдаж уг системийг аймагт нэвтрүүлэх 5 сургагч багш аймгийн нийт 122 байгууллагуудад ТАЦНС-ийн сургалтыг зохион байгуулж 4,5 сарын цалинг системд орууллаа.

**Татварын хэлтэс:** Татвар төлөх хуулийн хугацаа, татварын тайланг тушаах хуулийн хугацаа, хуулийн хариуцлага, цахим төлбөрийн баримт бүртгэх заавар, мэдээлэл засварлах, алдаатай баримт засварлах, татварын тайлан шивэх заавар, цахим төлбөрийн баримтад сугалааны азтан болсон иргэдийн баталгаажуулалт, нууц үг олгох, солих гэх зэрэг татварын албаны бүх мэдээ мэдээллийг нэг цэгийн үйлчилгээнээс хүндрэл чирэгдэлгүйгээр, түргэн шуурхай үйлчилэн татвар төлөгчдийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх нээлттэй утсыг иргэдэд зарлаж, утсаар болон e-мэйл хаягаар, ажлын байранд нь, хэсэгчилсэн, нэг цэгийн үйлчилгээний танхимаар дамжуулан татвар төлөгчдөд заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

**Худалдан авах ажиллагааны хүрээнд:** 2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 94 нэр төрлийн 23,699,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна. Үүнд:6-р сард нийт 493.8 сая төгрөгийн 6 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг

цахимаар зарласан байна. Мөн тухайн сард 20 нэр төрлийн тендерийн нээлт хийж 987.2 сая төгрөгийн 9 нэр төрлийн тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна. 4 тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна. 7 нэр төрлийн тендер шалгаруулалт үнэлгээ хийгдэж байна.

**Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчт эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит 11 байгууллагаас ирсэн санал хүсэлтийг тухай бүр хариуг шийдвэрлэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр 4 тогтоол гаргуулан хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар тогтоолын дагуу нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулахаар зарыг BBS телевизид хүргүүлээд байна.

**Санхүүгийн хяналт, аудитын алба:** Хүнс хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яамны 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 10/231 тоот хүсэлтийн дагуу албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаж улсын хэмжээнд хийгдэх нэгдсэн санхүүгийн хяналт шалгалтыг аймгийн Мал эмнэлгийн газарт хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 45003.6 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 44223.6 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 7 заалттай хугацаатай албан шаардлага, 780.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 2 акт тогтоов. Мөн Төрийн аудитын газраас ирүүлсэн албан шаардлагын дагуу Мөнххаан сумын албан тушаалтантай холбоотой төлөвлөгөөт бус 3-н хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргаж Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэв. Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт төлөвлөгөөт хяналт шалгалтыг 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн, одоо хяналт шалгалт үргэлжилж байна.

Тус алба нь хагас жилийн тайлан мэдээг 06 дугаар сарын 25-ны дотор Сангийн яамны Төсвийн эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлээ.

**Статистикийн хэлтэс:** Хүн ам, орон сууцны тооллогын хүснэгтүүдийн тоо мэдээллийг нягтлан, шалгаж, анхаарал татсан хүснэгтүүдийг ахин тодруулаж ажиллалаа. Мөн хүн ам, орон сууцны тооллогын хураангуй тайланг бичиж төвд дамжуулан, тооллогын товчоогоор хянуулан аймгийн тооллогын комисст танилцуулахад бэлэн болоод байна. Хүн ам, орон сууцны тооллогын аймгийн нэгдсэн тайлангийн хүснэгтүүдийг хийж номны эхийг бэлтгэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны /Малын ашиг шим болон газар тариалангийн судалгаа/ 1 дүгээр улирлын мэдээллийг сонгогдсон 8 сумын 8 багийн 160 өрхөөр бөглүүлэн татан авч, хянаж шалгах ажил хийж, програмд оруулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлээд байна.

Хагас жилийн малын түүвэр судалгааг 2020 оны 05 дугаар сарын 25-наас 31-ний хооронд 13 сумын 67 багийн түүвэрлэгдэн ирсэн 1642 өрх, ААНБ-ыг цуглуулах ажил хийгдэж байна. Энэхүү ажлын хүрээнд сумдын Засаг дарга нарт хэлтсийн даргын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 25 тоот албан бичгээр сумдад хагас жилийн малын түүвэр судалгааг чанартай зохион байгуулж явуулах, бэлтгэл ажлыг хангах талаар чиглэл өгч ажилласан бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/344 дүгээр захирамжаар сумдын тооллогын комисс, түүний ажиллах зарчмын хүрээнд зөвлөмж, үүрэг, даалгаврыг өгсөн. Мөн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Түмэнцогт, Мөнххаан, Уулбаян, Дарьганга, Наран, Онгон сумдад хяналтын 2 групп ажилласан. Түүвэр судалгааны дүн нэгтгэн бүрэн шалгаж 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр ҮСХ-нд дамжуулан ажиллалаа.

### **Гурав. Хууль эрх зүйн салбарт:**

Баруун-урт сумын Засаг дарга, Тамгын газрын захирамж, тушаалыг хянасан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл стратеги судалгааны хүрээлэнд аймаг, сумдын ерөнхий мэдээлэл, агентлаг байгуулагуудын 2018-2020 оны төсвийн орлого зарлагыг татан авч нэгтгэн явуулсан.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** 06 дугаар сарын байдлаар дараах бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ Хүлээн авсан мэдүүлгийн тоо-198, анхны бүртгэл-26, өмчлөх эрх шилжих гэрээ-24, барьцааны гэрээ-125, бүртгэлд өөрчлөлт оруулах -2, лавлагаа хуулбар-18, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-52

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ Хүлээн авсан мэдүүлгийн тоо-150, анхны бүртгэл-19, өмчлөх эрх шилжих гэрээ-31, барьцааны гэрээ-86, бүртгэлд өөрчлөлт оруулах -6, лавлагаа хуулбар-5 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-55, нийт бичигдсэн лавлагааны тоо-5 Хуулийн этгээдийн бүртгэл 2020 оны 06 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1193. Тухайн сард шинээр нийт ХК-2, ХХК-619, төрийн бус байгууллага-118, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -22, улсын төсөвт үйлдвэрийн газар-137, нөхөрлөл-75, хоршоо-80, хадгаламж зэлийн хоршоо-4, сан-3, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-42, шашны байгууллага-11, хэвлэл мэдээллийн байгууллага-2, татан буугдсан улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-59, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-196, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-413, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт хийсэн-443, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон-406, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг-167, лавлагаа-4, нэрийн баталгаажуулалт-12

**Иргэний бүртгэл:** Иргэний бүртгэлийн тасагт 06 дугаар сарын байдлаар нийт 133 төрөлт, гэрлэлт 39, гэрлэлт цуцлалт 2, үрчлэлт 2, эцэг тогтоолт 7, овог нэр өөрчлөлт 6, нас баралт 44, үндэсний энгийн гадаад паспорт 7, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 90, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 550 тус тус бүртгэгдэж олгосон байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Алба хаагчдын мэдлэг, боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг төлөвшүүлэх үүднээс 140 цагийн сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/178 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ын дагуу алба хаагчдаас онолын шалгалтыг авахад 89,5 хувтай үнэлэгдсэн байна.

Сүхбаатар аймгийн Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулан нийт албан хаагчдыг урьдчилан сэргийлэх элэгний В,С вирус илрүүлэх, цусны дэлгэрэнгүй, биохими, серилогийн шинжилгээ, элэгний “В” вирус илрээгүй 6 албан хаагчдыг В вирусээс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан.

Монгол Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийтийг хамарсан бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалт, дадлага зохион байгуулаагүй хэдий ч алба хаагчдын албаны бэлэн байдал, ур чадвар, алба хаагчийн сахилга, ёс зүйн төлөвшил, цэрэгжилч, жагсаалч байдал, бие бялдрын норматив гэсэн чиглэлээр шалгалт авсан. .15 алба хаагч –А, 11 алба хаагч –В буюу 85.87 хувьтай үнэлэгдсэн

Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2020 оны эхний хагас жилийн байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 11 ялтны 42470,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 87 ялтны 79100.0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 83 ялтны 58700.0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 15 ялтны 62870.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх урьд оны үлдэгдэл 7 ялтны материал дээр шүүхээс шинээр 18 ялтны 7140 цагийн ялын материалыг хүлээн авч, 8 ялтны 3865 цагийг хорих ялаар солиулж, 1 ялтны 320 цагийг шүүхээс хүчингүй болгож, 11 ялтны 290 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 5 ялтны 1426 цагийн ял эдлэлтэд хугацаа тавин ажиллаж байна.



теле хичээлийн бичлэгт орж хичээл заалаа. Багш Д.Энхнаран зуны 1 сарын хугацаанд зохион байгуулах үндэсний шинжээчийн багт орж ажиллахаар шалгарав.

Сүхбаатар аймгийн хэмжээнд бүрэн дунд боловсролын 595, суурь боловсролын 852 гэрчилгээ үнэмлэх ирсэнээс ерөнхий боловсролын 16 сургуулийн төгсөгчдийн гэрчилгээ үнэмлэх олгох ажлыг Боловсрол, соёл урлагийн газрын ажлын хэсэг байгуулж удирдан зохион байгууллаа. Сурагчдын боловсролын гэрчилгээ, “Б” маягт, хувийн хэргүүдийг БСУГ-т татан авч дүнгүүдэд түүврийн аргаар тулгалт хяналт хийж, тайланг БСШУСЯ-нд хүргүүлсэн.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж 70 байгууллагын 70 албан хаагч, Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 12 иргэнийг хамруулсаны зэрэгцээ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Прокурор болон Боловсрол соёл урлагийн газартай хамтран “Хүүхдийн эрхийн зөрчил ба хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг” сэдвээр ТВ хэлэлцүүлэг зохион байгуулж, 6 дугаар сарын 1-ний өдөр орон нутгийн телевизээр олон нийтэд хүргэв

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн зөрчлийг илрүүлэх, иргэдийг сонсох, Корона вируст Ковид-19 халдварт цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэрээр айлчлах” 1 сарын аян аймагийн хэмжээнд зохион байгуулж, гамшиг онцгой байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгааллын талаар хууль тогтоомж төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх хамтарсан багт мэдээлэл арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг 8 суманд зохион байгуулсан.

Өсвөр үеийн охид, хөвгүүд болон эцэг эхчүүдэд, бодит амьдралаас сэдэвлэсэн өөрсдийн чин сэтгэлийн хүүрнэлээр дамжуулан үерхэл нөхөрлөл, хайр дурлал, бэлгийн амьдралтай холбоотой асуудалд хариуцлагатай ханддаг болгох, улмаар тэдний бэлгийн боловсрол болон гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор өсвөр насны ээжүүдийн бодит амьдралаас сэдэвлэн өсвөр үеийн охид, хөвгүүдийн хэрэгцээнд нийцсэн, энгийн үг хэллэгтэйгээр бүтээсэн “Даль жигүүр” тайз дэлгэцийн монологийг 2020 оны 06 дугаар сарын 01-нд аймгийн SB телевизээр олон нийтэд хүргэсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/263 дугаар захирамжаар “Хамгаалагдсан хүүхэд-хариуцлагатай аав, ээж нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах” удирдамж гаргаж 2 сарын аян зохион байгуулан аймгийн төвийн гудамж, замд тээврийн хэрэгсэлд хүүхдийг тээвэрлэхдээ зориулалтын нэмэгдэл суудал буюу хамгаалах хэрэгсэл хэрэглэж байгаад хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр нэгдсэн шалгалтыг зохион байгуулж ажилласан. Уг аяны хүрээнд Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан цахим уралдааныг 05 сарын 30-ны өдөр зарласан ба уралдаанд 45 хүн оролцож амжилттай оролцсон. 30 хүнд хүүхдийг автомашинд тээвэрлэх зориулалтын суудлыг гардуулж өгөв.

Хүүхэд эрхийн тухай, Хүүхдийн хамгааллын тухай хуулиудын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагатай холбоотой зүйл заалтыг сурталчлах ажлын хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомжийг олон нийтэд таниулах зорилгоор телевизийн суваг болон байгууллагынхаа пейж хуудсаар видео шторк 2, постер 10 ширхэгийг хийж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Хүүхдийн байгууллагын 95 жилийн ойн хүрээнд байгууллагын 2017-2020 оны үйл ажиллагааны эмхтгэл сэтгүүлийн эхийг бэлтгэсэн.

“Гэрээр айлчлах” аяны хүрээнд Гэр бүлийн харилцаа, Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөгөө хүргэх мөн хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж эрсдэлтэй айл болон гэр бүлийн орчинд хүчирхийлэл байгаа эсэхийг илрүүлэх зорилготой Залуучуудын хөгжлийн төвийн мэрэгжилтнүүд нийт 400 айлаар орсон байна.

#### **Соёл урлагийн чиглэлээр**

**Хөгжимт жүжгийн театр:** BBS телевиз болон Монголын цахилгаан холбооны Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран Жаахан шарга театрын ШИЛДЭГ уран

бүтээлийн түүвэр LIVE тоглолт 05-р сарын 29-ний 19:00 цагаас BBS TV-ээр болон BBS телевиз гэсэн цахим хуудсаар шууд дамжуулж 23 мянган хүнд хүргэсэн.

Өвөрхангай аймгийн МУСГЗ Н.Оргийн нэрэмжит Хөгжимт драмын театрын эрэгтэй уран бүтээлчид ХЖТ-тай танилцах үйл ажиллагаа зохион байгуулсан.

**Нийтийн номын сан:** Коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор уншлага үйлчилгээ, ном олголт танхимаар хийгдээгүй бөгөөд эхний 6 сарын байдлаар танхимаар Байнгын уншигч-250, Бүх олгосон ном-1588, Ирэгсэд-873 байна.

Нийтийн номын сангуудын үйл ажиллагааг нээсэн тул 06 дугаар сарын 22-ноос хэвийн ажиллаж эхэлсэн.

Шинээр баркод хэвлэгч захиалан үйлчилгээндээ нэвтрүүлэн, 1050 гаруй номонд шинээр баркод нааж гарган үйлчилгээнд оруулж, Ерөнхий данс буюу нэг бүрчилсэн бүртгэлийг шинэчлэх тусгай төлөвлөгөө гаргаж, данс хуулалтанд мэргэжлийн байгууллага, /МУҮНС/ мөн ахмад номын санч С. Халтарыг авчран заавар зөвлөгөө авч ажилласан.

2018 онд тооллогоор номыг номоор төлсөн 245 ширхэг номыг техник ажиллагаа хийж хүлээлгэн өгсөн бөгөөд 298 номыг электрон каталогит оруулан, баркод нааж, урагдаж гэмтсэн номыг сэлбэн заслаа. Мөн тогтмол хэвлэлийг улирал, он оноор нь багцлан дугаарлан, хавтаслан үдсэн.

Гэртээ бие даан ном унших, бүтээх, хөгжих, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, уншсан номын тэмдэглэл хөтлөх, уншсан номныхоо агуулгыг зураад бүтээлчээр өөрөө өөрсдийгөө хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Номын тэмдэглэл хөтлөх” уралдаанд А.Лхагвасүрэн /1-р 10 жил /, Э. Даваасугар /1-р 10 жил/ шалгарч, гарын бэлэг, номоор шагнаж урамшуулав.

"Монголын Нууц Товчоонд нэвтрэхүй" цуврал нэвтрүүлэг: Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9-р зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг үндэслэн Ерөнхийлөгчийн 2004 оны 02 сарын 18-ны өдрийн "Монголын Нууц товчоо"-г эрхэмлэн дээдлэн тухай 23 дугаар зарлигийн дагуу Цахим үйл ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд "Монголын Нууц Товчоонд нэвтрэхүй" цуврал нэвтрүүлгийн анхны дугаарыг онлайн хэлбэрээр хүргэхэд 1000 гаруй хүн харж, тандалт хийсэн байна. Аймгийн Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн, 2-р БДС-ийн түүх, нийгмийн багш С. Мандахтуяа нар оролцсон.

Цахим үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Л.Сарантуяагийн “Зүчи хаан” түүхэн роман, Луи Замперминий амьдрал, бодит түүхээс сэдэвлэн бичсэн “Мятаршгүй” ном, монгол ардын үлгэр “Могжоохон дагатай жогжоохон хүү” үлгэрийг цахимаар сурталчилсан.

Хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдэд гэрээр нь зөөврийн номын үйлчилгээг хүргэж өгч ажилласан.

**Угсаатны зүйн музей:** Музейн видео танилцуулгыг бэлтгэж олон нийтэд танилцууллаа.

Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 50 ш хөөргөөр видео бичлэг хийгдэж олон нийтэд танилцуулж, видеог сан хөмрөгт хадгаллаа.

Цахимаар байгууллагын үйл ажиллагааг сурталчилах ажлын хүрээнд хариуцсан албан хаагчид үзмэрт цахим тайлбар хийн байгууллагын цахим хуудаст байршууллаа.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлыг зохион байгуулж 1 байгууллагын эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

Уул уурхайн тээвэрлэлт эхлэхтэй холбоотойгоор Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдал, өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах зорилгоор Сүхбаатар сумын Дөхөмийн уурхайд ажлын хэсэг ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн санал авах 64 хэсгийн хорооны санал авах байрны 9333 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийж 31538 сонгогчийн гарыг

халдваргүйжүүлж, халууныг хэмжин, маск бээлийг үйлчлэн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлж ажилласан.

Хүүхдийн эндэгдлийн магадлан хэлэлцэх хурал, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хагас жилийн чанарын үзүүлэлтэд дүгнэлт хийх болон цаг үеийн асуудлаар цахим хурлыг 6 удаа хийж 180 эмч эмнэлгийн ажилчдыг хамруулсан байна.

6 дугаар сард гэрийн ажиглалтад байгаа 19 иргэнд анхан шатны эрүүл мэндийн байгууллага, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллалаа.

18 нэр төрлийн вакцин био бэлдмэл, тарилгын тоног төхөөрөмжийг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанаас татан авч анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан тасралтгүй ханган ажиллаж байна.

Хувийн хэвшлийн 3 эрүүл мэндийн байгууллагад “Тусгай зөвшөөрөл, халдвар хамгааллын бэлтгэл бэлэн байдал”-ыг хангуулах чиглэлээр дэмжлэгт хяналт хийсэн.

Дотрын сувилагчдын нийгэмлэгтэй хамтран “Сувилахуй тусламж үйлчилгээний эрсдэл аюулгүй байдал” сэдэвт сургалтад АНЭ, өрх сум, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 30 ахлагч сувилагчийг мөн 10 сумын ЭМТ-ийн их эмч, эх баригч нарыг АНЭ-ийн төрөх тасаг дээр 14 хоногийн ажлын байрны дадлага сургалтад хамрууллаа.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Олон улсын чанарын менежментийн тогтолцооны шаардлага ISO 9001-2015 стандартыг нэвтрүүлэх баримт бичгийн боловсруулалтыг хийж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээ.

Малчин ХХЭ-ийн нийгмийн даатгалыг нөхөн тооцох хуулийн дагуу оны эхний хагас жилд 173 малчин, 3 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний нийгмийн даатгалын нөхөн тооцолтыг баталгаажууллаа.

Орон нутгийн 2 ТВ-ээр НД-ын хууль журмын талаар мэдээлэл, сурталчилгааг гэрээний дагуу тогтмол явуулж байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн талаар:** 2020 оны 6 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 674 иргэнээс эмэгтэй 321 иргэн 47,6%, бүртгэлтэй ажилгүй иргэн 488 иргэнээс, эмэгтэй 230 иргэн 47,1% байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн START-UP сургалтыг “Бэст Мэтод” сургалтын байгууллагатай хамтран 6 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулсан. START-UP сургалтанд 13 сумын 50 залуус 16 баг болон оролцож бизнесийн шилдэг санаагаа танилцуулснаас 8 баг нь дараагийн шатны бизнес хурдасгуурт оролцох батламж гардуулан нийт сургалтанд хамрагдсан залуучуудад сертификат олгов. Шалгарсан 8 баг нь 5 долоо хоногийн хугацаатай хурдасгуурт арга хэмжээнд хамрагдаж амжилттай оролцсон эхний 5 багт тус бүр 10 сая төгрөгний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэлээ.

Мөн Улаанбаатар хотын Вэст Мэтод ХХК-н дэргэдэх "Бест инноваци" сургалтын байгууллагатай хамтран "БИЗНЕСЭЭ ХӨГЖҮҮЛ" аж, ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж байна. Сургалтанд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 13 сумын 40 иргэн хамрагдсан.

Баруун-Урт суманд Зохион байгуулалттайгаар ажлын байрыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан БҮЛЭГ нь хөлсөөр аж ахуй нэгж, албан байгууллага, айл өрхийн хогийн ургамал түүж цэвэрлэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулалтыг дэмжих зорилгоор ТҮМЭНЦОГТ СУМАНД ҮЙЛДВЭРЛЭВ борлуулалтын цэгийг шинээр нээлээ. Тус цэгээр 16 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний 26 нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулж байна.



Түмэнцогт суманд зохион байгуулалттай ажлын байр төсөлд ажилгүй 5 иргэнийг бүлэг болгон 5 сая төгрөгний "Блок" үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгч блок үйлдвэрлэх ажлыг эхлүүлсэн.

**Нийгмийн халамжийн талаар:** 06 дугаар сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 330,000 мян.төг, тэтгэмжинд 135000,0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 85000,0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 17,000.0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 34,000.0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 153000,0 мян.төг, алдарт эхийн одон 1000,0мян .төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 2250,0 мян.төг, насны хишиг 210000,0 мян.төг, цалинтай эхийн тэтгэмж 164,166.0 мян.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 48,400.0 мян.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 4,000.0 мян.төг, орон нутгаас 21600 сая.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгосон.

2020 онд гэрээ байгуулсан “Гээгийн ар” ХХК, “ Грийн мэпл ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, гар таяг 6, даавуун бүс 6, ширэн бүс 7, тэргэнцэр 5, суултуур 8, өвдгөвч 4, алхуулагч 1 ширхэгийг хэрэглэх шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүлээлгэн өгсөн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувилалд 6 дугаар сард 2 ээлжид 80 ахмад настныг амруулсан.

Амрагч нарт бариа засал, бумба, зөгийн балны татлага, шарлага, давсан зам, хаш чулуун ор, физик эмчилгээний аппарат, хөлний улны цэгэн массажны аппарат, ууц нурууны цэгэн массажны аппарат зэрэг эмчилгээнүүдийг явуулсан. Мөн ХХҮГ-н хамт олон багийн зохион байгуулалтаар нээлт, хаалтын үдэшлэг, караоке тэмцээн зэргийг ээлж бүрт зохион байгуулж хэвшээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 3 удаа хуралдаж 26 хүүхэд орсноос 19 хүүхэд асаргаа сунгагдаж, 4 - хүүхэд асаргаа шинээр тогтоолгосон, 3 хүүхэд эдгэрсэн тул цуцлагдсан.

ХХҮЕГ-с эрх авсан “ОЗОН СЕРВИС” ХХК-тай гэрээ байгуулан сэргээн засахын II ээлжийн үйлчилгээг 2020 оны 06 дүгээр сард 10 хоногийн хугацаатайгаар 20 ахмадад үзүүлж байна. Үүнд: эмчийн үзлэг, бариа засал, бумба тавих, зөгийн балны татлага, цахилгаан массажны аппарат, хаш чулуун ор, хөлийн улны цэгэн массаж, соронзон зүү, улаан гэрлэн шарлага, төөнүүр зэрэг эмчилгээнүүдийг хийж үйлчилж байна.

2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр аймгийн Улаан загалмайн хороотой хамтран зорилтот болон хөгжлийн бэрхшээлтэй 156 иргэнд 5 хоногийн 7020000 төгрөгийн өдрийн үйлчилгээг үдийн өмнө 16 иргэн , дараа 16 иргэнийг хүлээн авч өдрийн 2 ээлжээр нийт 32 иргэнд 4 цагийн хугацаатай өдрийн үйлчилгээг хамтран явуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Баруун-Урт сумын “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ” авагч 659 өрхийн хөдөлмөрийн насны 1385 иргэн хамрагдаж байгаагаас хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлээгүй 184 өрхийн 220 иргэн байна. ХХҮГ-н хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн нар 06 дугаар сарын 18-ны өдөр хүнсний эрхийн бичгийн журмын шалгуур нөхцөл, "Өрхийн гишүүн - Иргэний үнэлгээний хуудас", шинэ төрлийн коронавирустэй холбоотой Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг танилцуулж, 2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төслүүд болон ажил хөдөлмөр хэрхэн эрхлэх талаарх мэдээллийг 60 иргэнд өгч ажилласан.

Сургалтын төгсгөлд дээрх иргэдээс зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ, хөдөлмөрт бэлтгэх сургалт, мэргэжил олгох сургалт, аж ахуй эрхлэлтийн сургалт, өдрийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэсэн.

Сургалтанд ирсэн иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 60 амны хаалт, гарын авлагыг тарааж, зөвлөмж өгсөн.

Баруун-Урт сумын зорилтот бүлгийн 50 өрхөд Монголын улаан загалмайн хороотой хамтран хүнс тэжээл болон ахуйн хэрэглээний эд зүйлийн тусламж үзүүлж байна.

#### **Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:**

**Дэд бүтцийн салбарт:** Баруун-Урт суманд 2020 оны 5 сарын 25-наас 6 сарын 5-ны өдрүүдэд 4-н байршилд, Мөнххаан сумын Бүрэнцогтод 2020 оны 5 сарын 28-ны өдөр 5-н байршилд газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдаа танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулагдсан. Уг газар эзэмших эрхийн дуудлага худалдаануудаас аймаг, сумын төсөвт нийт 88,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Дарьганга суманд байрлах газрын хэмжилт хийхэд ашиглагдах СYA-2 байнгын ажиллагаатай GNSS станцыг байрлуулж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Баруун-Урт сумын байр зүйн зургийг MNS6702:2017 стандартад шилжүүлэх ажил хийгдсэн.

Газрын кадастрын мэдээллийн сангийн веб хувилбарт иргэд, ААН, байгууллагаас гаргасан нийт 35 өргөдөл бүртгэгдсэн. Үүнд Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 17 өргөдөл, шинээр газар эзэмших 1 өргөдөл, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 3 өргөдөл, Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах 3 өргөдөл, Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа газар өмчилж авах 4, Газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 1, Өмчлөх эрхийн талбай хэмжээнд өөрчлөлт оруулах 2, өргөдөл тус тус хүлээн авч бүртгэгдсэн.

Аймгийн Засаг даргын 1 удаагийн захирамжаар 1 өргөдөл шийдвэрлэгдснийг газрын кадастрын мэдээллийн санд захирамжийг бүртгэсэн. Нотариатчийн 17 гэрээг бүртгэж баталгаажуулсан. Дундын сангаар дамжуулан 26 нэгж талбарт Э дугаар захиалан хүлээн авсан. Газар эзэмших эрхийн гэрчилгээг 4 иргэн, ААН, байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан байна.

Газрын кадастрын мэдээллийн сангаас 55 иргэн аж ахуй нэгж, байгууллагад кадастрын үнэт цаасан дээр 165 ш хувь баталгаажсан кадастрын зураглалаар үйлчилсэн.

ГЗБГЗЗГазрын даргын 2020 оны А/46 дугаар тушаалыг үндэслэн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг аймгийн хэмжээнд хэрэглээнд бүрэн нэвтрүүлээ.

ГЗБГЗЗГазрын даргын 2020 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмын дагуу Сүхбаатар, Халзан, Асгат, Түвшинширээ, Уулбаян сумдын 2020 оны Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбаруудыг цахим системд оруулан батлаж хэрэгжилтийг хангах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон тус газрын хооронд 2019 оны 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээнд заасан “Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын Сүхбаатар аймгийн 5602 цэгийг 2020 оны 05 сарын 21-ний өдрөөс эхлэн одоогийн байдлаар 1676 цэгийн үнэлж, мэдээллийг хадгалаад байна.

Дарьганга, Наран, Онгон сумдад ГХБХБГ-ын холбогдох мэргэжлийн хүмүүс ажиллаж Дарьганга сумын Ганга нуурын бохирдол ширгэлтээс хамгаалах төслийн ажилтай газар дээр нь танилцлаа.

Барилгын материалын, сорилт шинжилгээний лабораторит 9 шинжилгээ хийгдсэн байна. Бетоны үл эвдэх аргаар-0 цэг цохиж, Тоосго-0, Бетон шоо-6, Элс-0, Хайрга-2, Дайрга-1, Явган зам-0, шинжилгээ хийн үр дүнг боловсруулан цаг тухай бүрт нь хариуг олгон ажиллаа. Барилгын материал, хийц бүтээцийн шинжилгээний хариуг стандартын дагуу архивлан хадгалж байна.

**Хөдөө аж ахуйн салбарт:** Үлийн цагаан оготной тэмцсэн талбайг хүлээж авч тайлан мэдээг нэгтгэж ХХААҮЯамруу хүргүүлсэн.

ХХААҮЯамны сайдын А/153 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Эрдэнэцагаан, Дарьганга сумдад сум дундын отрын нөөц тогтоох ажлаар ажилласан боловч отрын бүс нутгаар авсан газрууд малын тоо толгой жилээс жилд өссөнтэй холбогдуулж тогтоолын хэрэгжилт хангагдахгүй, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхацсан, хилийн зурвас, ашигт малтмалын газруудтай давхацсан зэрэг дутагдалууд гарч дахин төлөвлөх шаардлагатай байна. Сумдад аймгийн Засаг даргын 1/609 тоот “Чиглэл хүргүүлэх” тухай албан бичгийг сумдад хүргүүлээд байна.

2018, 2019 оны ноос, арьс ширний урамшуулалд хамрагдхаар материалаа ирүүлсэн 576 малчдын залруулгыг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

7 хоног бүрийн 3 дахь өдөр мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдолын талаар мэдээг сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлэн ажилласан.

06 сарын 25-ны байдлаар нийт төллөвөл зохих ингэний 71.2% буюу 1187, гүүний 56.3% буюу 59541, үнээний 59.8% буюу 63426, эм хонины 83 % буюу 773661, эм ямааны 81.8 % буюу 472591, толгой эх мал төллөж гарсан төлийн 96,2% бойжиж байна.

Нийт том малын 0.9 % буюу 34165 том мал зүй бусаар хорогдоод байна. Үүнд: Тэмээ 16, адуу 1389, үхэр 2811, хонь 16349, ямаа 13600 хорогдсон байна.

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.0 тэр бум төгрөгний санхүүжилтаар 42 ширхэг гүн өрмийн худгийг 4 багц болгон тендер зарласан. 1-р багцанд 238,9 сая/төг, 2-р багцанд 243,8 сая/төг-ний санхүүжилтаар “Голденхилл” ХХК нь гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан. 3-4-р багцад гүйцэтгэгч шалгараагүй тул дахин тендер зарлагдаад байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн хүрээнд нийт 14 ширхэг гүн өрмийн худгийг 2 багц болгон тендер зарласан. Тендерт “Уриндрлинг” ХХК, “Сойл-инженеринг” ХХК, “Ланд-тест” ХХК-нууд орж ирсэн боловч тендерийн баримт бичиг шаардлагыг хангаагүй тул дахин тендер зарлаад байна.

Шинээр үйлдвэрлэл байгуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч, 30 ААНэгжээс 3,1 тэр бум төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг хүлээн авч программд шивж оруулаад байна.

**Мал эмнэлгийн газар:** Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалтын арга хэмжээг орон нутагт зохион байгуулж нийт 2,625,866 мянган мад хамрагдахаас 2,437,623 мян мал хамрагдаж, дархлаажуулалт 92,8%-тай хийгдээд байгаа ба сумдын МЭТ-аас малчны гарын үсэгтэй эх материалыг холбогдох баримтын хамт мал эмнэлгийн цахим системтэй гүйцэтгэлийг тулган хянаж хүлээн авч МЭГГазарт хүргүүлэхээр бэлтгэл хангаж байна.

Орон нутгийн мал эмнэлгийн чадавхийг сайжруулах зорилгоор МУЗГ, ХХААХҮЯ, МЭГГазраас 2020 онд аймгийн Мал эмнэлгийн газарт Лада маркын автомашин, 13 сумын МЭТасагт мотоцикль, компьютер, оффисын тавилга өгснийг аймгийн удирдлагууд гардуулан өгөв. Мөн аймгийн ЗДТГ-аас нөөц сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж 13 тасаг, 55 МЭҮН-д 68 ш халдваргүйтгэл хийх автомакс, 55 ш дуудлага үйлчилгээний бикс /халууны шил, чагнуур, ХХ хувцас ком 3ш/ зэргийг гардуулан өгсөн.

**Лабораторийн ажлын талаар:** Гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийсний дараах тандалт шинжилгээнд МЭЛ-оос ажлын хэсэг гарч Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумдын 45 өрхийн 675 цусны дээжийг авч УМЭАЦТЛ-т хүргүүлэн ажилласан.

13 Сумдын хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний шинжигээг нийт 4423 цусны дээж ирж бүртгэн авч МЭЛ-н шинжээч эмч нар шинжилгээг /Розбенгал/ хийж ажиллаж байна. Шинжилсэн дээж бүгд сөрөг гарсан. “Үхрийн цээж” өвчний халдварлалтыг тогтоох түүвэр шинжилгээг 6 суманд 180 дээжийг авч цуглуулан УМЭАЦТЛ-т хүргүүлэн ажилласан. 6 сард Халдварт өвчин оношлогдоогүй.

Адууны нийлүүлгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн ажлын төлөвлөгөөнд тусгасаны дагуу малчид ард иргэд гүү, болон хээлтүүлэгчийн цусны дээжинд шинжилгээг хүргүүлэн ажиллаж байна. Д.Батсуурь малчин 6 гүүний цусны дээжинд шинжилгээ хийхэд сөрөг гарсан байна. Дээжний хариуг малчинд хүргүүлсэн.

Ариутгал халдваргүйтгэлийг 6 сарын байдлаар автобус болон сонгуулийн хорооны намын байр зэрэгт 66,0 мянган м/кв талбайд хийж ажилласан байна.

**Уул уурхайн чиглэлээр:** ТТАМ-ын тухай хууль 2015 оноос хэрэгжиж эхэлсэнээс хойш аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл ААН—үүдэд огт олгогдоогүй бөгөөд 2019-2020 онд манай аймагт улс, орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа барилга, авто замын байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэгч нараас элс, хайрга, дайрга хэрэглэх карьерын зөвшөөрөл хүссэн хүсэлтүүд аймгийн ЗДТГ-т байнга ирсээр байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын дагуу ТТАМ ашиглах зөвшөөрлийг авто зам, барилгын ажлын гүйцэтгэгч компаниудад олгох шийдвэр гаргуулах хүсэлтийг ЗГХЭГ, УУХҮЯ, ЗТХЯ, БХБЯ-нд хүргүүлээд байна.

Баруун-Урт хотыг 2014-2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын зүүн хэсэгт шинээр дэд төв байгуулахаар төлөвлөгдөж, шинэ суурьшлын бүс үүсгэх, дахин төлөвлөлт, дэд бүтцийн төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан Цайрт минерал ХХК-ийн уулын баяжуулах үйлдвэрээс Дорноговь аймгийн Сайншанд хот руу бүтээгдэхүүн тээвэрлэлтийн чиглэл маршрутыг шинэчлэн тогтоолгох хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

**Зам тээврийн чиглэлээр:** Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй аймгийн төвийн 4-р тойргийн 9,1 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар далан, цементээр бэхжүүлсэн суурийн ажил бүрэн хийгдэж, 4 км асфальтбетон хучилт, ус зайлуулах хоолойн суурь цутгалтын ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Баруун-Урт сумын 1-р багт хийгдэх 420 у/м явган замын ажлын тендерт хамгийн сайн үнэлэгдсэн “Бэсүбконстракшн” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлээд байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Авто замын уулзварын гэрлэн дохио /Сүхбаатар, Баруун-Урт сум/”, ЗТХЯ/202002002 дугаартай ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Инносолошн” ХХК, “Хөл бөмбөгийн талбайн гаднах авто зогсоол”, СБАОНӨГ/202001018 дугаартай ажлын гүйцэтгэгч “Ханан салхит” ХХК-иудтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажлыг эхлүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Авто тээврийн салбарын 95 жилийн түүхэн ой тохиолдуулан Авто тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагч, иргэдийг төрийн болон яамны шагналд тодорхойлох материалыг хүлээн авч ЗТХЯ-нд уламжлаад байна.

06 дугаар сард 2732 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, 418 тээврийн хэрэгсэл шилжилт хөдөлгөөн хийгдсэн дүн мэдээтэй байна. Зорчигч тээвэр: Улаанбаатар хотоос Сүхбаатар аймаг чиглэлд автобусаар 1640 зорчигч, Сүхбаатар аймгаас Улаанбаатар хот чиглэлд автобусаар 1739 зорчигч зорчсон байна.

**Эрчим хүчний чиглэлээр:** Эрдэнэцагаан сумын 0.4кВ-ын шит тоноглолд их засвар, Дарьганга сумын 15кВ-ын ЦДАШ-ын засвар, Мөнххаан сумын 1км 0.4кВ-ын ЦДАШ-ын шинэчлэлийг тус тус хийсэн.

АТП№35, 38, 92, 65, 57, 97, 58, дэд станцуудад гадна хамгаалалтын хашаа, трансформаторын ажлын тавцан хийсэн.

Халзан, Онгон, Шарбүрдний 35кВ-ын ЦДАШ-д урсгал засварын ажлууд хийгдсэн

Уулбаян сумын 35кВ-ын ЦДАШ-ын тулгуур № 363 солих ажил хийсэн

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** БОАЖГ-аас санаачлан аймгийн хэмжээнд Сүхбаатар аймгийн Бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах уралдааныг 2020 оны 03 сарын 18-ны өдрөөс 2020 оны 05 сарын 18-ны хооронд 2 сарын хугацаатай зарлаж шалгаруулалтыг хийсэн. Металл хийц, арьсан эдлэл, модон эдлэл гэсэн гурван ангилалд нийт 12 оролцогчийн 30 гаруй бүтээл дэлгэгдлээ. Металл хийцийн төрөлд 1-р байранд Б.Төгөлдөр Бударсудар ХХК, дэд байранд Б.Баярхүү, Гутгаар байранд Болорчимэг Дижитал ХХК, Модон ба чулуун эдлэлийн төрөлд 1-р байрыг Б.Баярхүү, дэд байранд Ц.Энхбаатар, гутгаар байранд Ц.Мөнхболд, арьсан ба эсгий

эдлэлийн төрөлд Б.Мөнх-Од Аринги брэнд, дэд байранд Гүндсамбуу Нутаг брэнд, гутгаар байранд Цээсүрэн эсгий урлал шалгарч Батламж мөнгөн шагналаар шагнагдлаа. Бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах уралдаанд нийт 3 сая төг зарцуулсан байна.

Иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх ая тухтай орчинг бий болгох зорилгоор 2019 онд Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 60x40 м хэмжээний газарт бичил цэцэрлэг байгуулах ажлыг эхлүүлж, “Мөнхөд ундарч дэлгэрэх” ХХК-иар 9500.000 төг-р явган зам, сүүдрэвч зэрэг тохижилтыг хийлгэсэн. 3 төрлийн 500 гаруй мод сөөгийг тарьсан. 2020 оны хаврын тарилтаар 133 м явган зам дагуу ургамалан хашлагаар 540 ш хайлаас тарьсан. Мод тарих нүх ухах, мод суулгац худалдан авах, усны комп, шланг авах зэрэг ажилд 3.2 сая төг-ийг зарцуулсан.

Баруун-Урт голын эхийн хашаа хамгаалалтыг үргэлжлүүлэн шинэчилж дуусгах ажлын тендерт “Тохижилт-Үйлчилгээ” ОНӨААТҮГ шалгарч, санхүүжилтийн 25.8 сая төгрөгийг олгосон ба гүйцэтгэл 100%-тай байна.

Сүхбаатар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Онгон сумын Цагаан худгийн булаг, Их булаг, Нүдэн булгийн эхийг засварлах ажлын гүйцэтгэгчээр Нарс мод ХХК шалгарч 39,0 сая төгрөгөөр уг ажлыг хийсэн байна.

### **Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил:**

**Мэргэжлийн хяналтын газар:** 2020 оны эхний хагас жилд хяналтын 18 чиглэлээр 326 объектод төлөвлөгөөт шалгалт хийгдэхээс 185-д нь хийгдэж, хамрагдалт 57 хувьтай байна. Шалгалтад хамрагдсан 185 объектын үйл ажиллагааг хяналтын хуудсаар шалгахад 24 буюу 14% нь их, 91 буюу 50% нь дунд, 65 буюу 36% нь бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бөгөөд шалгалтаар нийт 1154 дутагдал илрүүлсний 720 буюу 62 хувийг арилгуулах арга хэмжээ авч, хугацаа шаардлагатай зөрчлийг арилгуулахаар 434 заалттай 115 албан шаардлага хүргүүлж хэрэгжилт дунджаар 68 хувьтай байна.

Шалгалтын явцад дутагдал гаргасан 154 иргэн, аж ахуйн нэгжид 25.640.0 мянган төгрөг торгууль, 15.548.6 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн шийтгэл ногдуулж, торгуулийн барагдуулалт 80 хувьтай, нөхөн төлбөрийн барагдуулалт 100 хувьтай байна.

2020 оны эхний хагас жилд 114 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөснөөс 70 хувийг хамруулсан бөгөөд коронавируст халдвар “Ковид-19” цар тахалтай холбогдуулан зарим зөвлөн туслах үйлчилгээ хийгдээгүй хүлээгдэж байна.

Албан байгууллага, аж ахуйн нэгжид хийгдсэн зөвлөн туслах үйлчилгээний явцад нийт 686 дутагдал илэрсэний 420 буюу 61 хувийг арилгуулж, 266 заалт бүхий 69 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 60 хувьтай хангуулсан байна. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан 79 объектын үйл ажиллагааг хяналтын хуудсаар үнэлэхэд 22 буюу 27 хувь нь их, 25 буюу 31 хувь нь дунд, 35 буюу 42 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

“Ковид-19”-ын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвхжүүлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Газрын даргын 5 удаагийн тушаалаар хариуцлагатай жижүүрийн үүргийг давхардсан тоогоор 33 албан хаагч гүйцэтгэн, Улсын Онцгой комиссоос зарласан-2, Аймгийн Онцгой комиссоос зарласан 1 удаагийн дадлага, сургуулилтад бие бүрэлдэхүүнээрээ оролцож, болзошгүй үеийн бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг авч ажиллалаа.

Тайлант хугацаанд 1500 сорьц төлөвлөснөөс нийт 324 сорьцонд 955 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж гүйцэтгэсэн бөгөөд шаардлага хангаагүй 73 сорьц илэрсэн. Үүнээс хүнсний бүтээгдэхүүний 41, гадаад орчны 32 сорьц эерэг байна.

Эерэг сорьц нь нийт шинжилсэн сорьцын 22.5%-ийг эзэлж байгаа бөгөөд энэ үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 30.5%-иар буурсан байна.

Сорилт шинжилгээг мөнгөн дүнгээр авч үзвэл нийт 5.019.700 төгрөг, үүнээс дансанд төвлөрүүлсэн мөнгөн дүн 3.019.100 төгрөг, төлбөргүй хийсэн шинжилгээний үнэ мөнгөн дүнгээр 2.000.600 төгрөг байна.

Шинжилгээнд хамрагдсан нийт сорьцын 39.2 хувь нь төлөвлөгөөт, 57.0 хувь нь байгууллага, аж ахуй нэгж иргэний хүсэлт, 3.7 хувь нь урьдчилан сэргийлэх шинжилгээ эзэлж байна.

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 20 өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу 38 объектод төлөвлөгөөт бус шалгалт хийж 2 объектын үйл ажиллагааг түр зогсоож, 4 зөрчилд 10.700.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж, барагдуулалт 100%-тай байна.

### **Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил:**

#### **Баруун-урт:**

**Цаг үеийн ажлууд:** 8-р багийн нутаг дэвсгэрт 0,4 квт-ын шугамын дэд станц барих ажлын тендер зарлагдаж, шалгарсан гүйцэтгэгч ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өглөө.

9-р багийн нутаг дэвсгэрт 9 ширхэг цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг “Алсын солонго” ХХК гүйцэтгэж, ажлыг 100%-тай хүлээлгэн өгсөн.

7-р багийн 48 айл, 1-р багийн 60 айлын дээвэр засварын ажлыг “Хайлааст гарам” ХХК хийж гүйцэтгэж байна.

Аймгийн БОАЖГ, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран Уртын голын эхийг хамгаалах ажлыг хийж нийт 650 м газрыг шинээр хамгаалалтын хашаа барьж байгуулсан.

Аймгийн МХГ, БОАЖГ-тай хамтран Баруун-Урт сумын хэмжээнд байгаа химийн хорт болон аюултай бодисын судалгаа тооллого хийгдсэн.

#### **Баяндэлгэр:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Сумын засаг даргын А/57 дугаар захирамжаар 2020 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 05 дугаар сарын 25-наас 31-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал хураалт 06 дугаар сарын 24-ны өдөр зохион байгуулахтай холбогдуулан сумын хэмжээнд согтууруулах ундаа, түүгээр үйлчилгээ эрхлэхийг 06 дугаар сарын 23-ны өглөөний 8 цагаас 06 дугаар сарын 26-ний өдрийн 10 цаг хүртэл түр хориглох шийдвэр гарган орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллагуудыг холбогдох мэдээллээр ханган зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

**Соёл:** Эх үрсийн баярыг угтаж “Аялгуут нас” цахим уралдааныг гурван насны ангилалаар зохион байгуулж 1,2-р байрыг насны ангилал тус бүрд шалгаруулж урамшууллаа.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Суманд Монгол, Бодь, Практикал, Давхар даатгалын төлөөлөгчид малын индексжүүлсэн даатгалыг хийж хонь 2,493 , ямаа 12,144 , адуу 674, үхэр 2,796 нийт 18,107 толгой малд МИДаатгал хийгдэж одоогоор 9,385,387 төгрөгийн хураамжийг банкинд төвлөрүүлүүлээд байна.

Засгийн газрын 185 дугаар тогтоол, ХХААХҮСЯамны 2020 оны А/89 дүгээр тушаал, аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан огтонотой энгийн механик, биологийн аргаар тус суманд 10000 га бэлчээрийн талбайд тэмцэх ажлыг зохион байгуулсан. Уг ажилд тухайн бэлчээрийг ашиглаж байгаа 30 малчин өрхийг хамруулж 6 үлийн ухагч, 9 үлийн утагч 40 шувууны үүр босгож 10 авто машин 12 мотоцикл дайчлан ажилласан.

**Байгаль орчны чиглэлээр:** Нийтийн эзэмшлийн талбай буюу сумын төвийн ногоон байгууламжийн өргөтгөлд 4 төрлийн 1150 мод бутыг тарьж усалгаа арчилгааг зохих хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.

#### **Дарьганга:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ажлын хэсэг Ганга нуурт хэрэгжиж буй төслийн гүйцэтгэгчтэй уулзаж, уг төслийг үргэлжлүүлэх, тохижилтын ажуудыг эхлүүлэхээр шийдвэрлэв.

УИХ-ын ээлжит сонгуулийн санал авах ажиллагаанд 59 төрийн албан хаагч 4 хэсэгт ажилласан.

2020 оны хагас жилийн байдлаар сумын ЗДТГ-т ирүүлсэн 518 өргөдөл иргэдээс ирсэнийг ангилж үзвэл доорх байдалтай байна.

1. Хөдөлмөр халамж үйлчилгээний асуудлаар	175/33,78%
2. Улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар	79/15,25%
3. Тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлаар	82/15,83 %
4. БОАЖ –ын асуудлаар	15/2,89 %
5. Газар	26/5,01%
6. БЗД-нарт	128/24,71%
7. Гэр орон байр хүссэн асуудлаар	9/1,73%
8. Ажлын байртай холбоотой асуудлаар	3/0,57%
7. Бусад	1/0,19%

**Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:** “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ” сэдэвт цахим сургалтад 2 мэргэжилтэн оролцож, цахимаар авсан сорилын шалгалтанд тэнцсэн.

Хагас жилийн байдлаар цахим сургалт 9, дотоод сургалт 36, гаднаас 5, цахим сурталчилгаа 397- г хийж, 4180 хүнд 5 чиглэлээр сурталчилгаа хийсэн бөгөөд үүний 3604 нь цахим орчинд, 576 нь төрийн байгууллагаар үйлчлүүлэгч иргэн байна гэсэн дүн мэдээтрэй байна.

“Хамгаалагдсан хүүхэд-хариуцлагатай аав ээж” аяныг сумын ЗДТГ, ЭМТ, Цагдаагийн хэсэг хамтран зохион байгууллаа.

**Эрүүл мэнд:** УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан аймгийн ЭМГ-ын даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ХШҮ-ний баг ирж , мэдээлэл, зөвлөмж өгч хяналт шалгалт хийж ажилласан.

“Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хүрээнд сумын Цагдаагийн хэсэг, ЭМТ –ийн албан хаагчид иргэд, хүүхдийн дунд сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан.

#### **Мөнххаан:**

**Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:** Сумын Засаг даргын 2018/08/06-ны өдрийн А/70 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг МХГ-ын 2020/06/18 ны өдрийн 270 албан тоотын дагуу 27 дэлгүүр худалдаа үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж тамхины зөвшөөрлийн хугацаа дууссан 3 дэлгүүрийн тусгай зөвшөөрлийг шинээр олгож 750,0 мян төгрөгийг 100120400941 дансанд төвлөрүүлсэн. Мөн шалгалтаар ОХУ-аас импортолсон 2020 оны 02 сарын 10,18 ны өдрүүдэд үйлдвэрлэсэн 308 13 4Р цувралын дугаартай Сайра нэрийн нөөшөлсөн загас 5 дэлгүүрээс 24 ширхэг гарсныг хураан авч устгал хийж тайлан мэдээг зурагжуулан аймгийн МХГ-т хүргүүлсэн.

**Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр:** МЭТасаг 242 гэрчилгээнд хянан баталгаажуулалт хийсэн. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 27908 үхэр хамруулж, 55816 м/т вакцин зарцуулсан. Хагас жилийн мал тооллогын ажилд 10 төрийн албан хаагч ажилласан байна.

**Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр :** 280,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг “Хунт өгөөж” ХХК хийж гүйцэтгэн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.

Сумын төвд 11 цамхагт гэрэлтүүлэг байрлуулах ажлын тендерт “Алсын солонго” ХХК шалгарч, өөрсдийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна.

Сумын засаг даргын 2020 оны А/31 дүгээр захирамжаар 2 нэгж талбарт үйлчилгээтэй орон сууцны зориулалтаар , мөн 03 дугаар сарын 26-ны өдрийн А/37 дугаар захирамжаар уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар 5 нэгж талбарт тус тус газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Нийт 7 нэгж талбарын

дуудлага худалдааны үнэ болох 20.318.880 төгрөгийг төрийн сангийн 100120000943 болон 100120400943 тоот дансуудад төвлөрүүлээд байна.

11 монгол тарвагыг авчирч Мөнххаан ууланд нутагшуулсан.

Сумын төвийн худалдааны гудамж дагуух 400м замын ажлын тендерийг Ханан салхит ХХК авч замын ажлыг эхлүүлсэн ба ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

**Хөдөлмөр эрхлэлт халамж, нийгмийн хамгааллын чиглэлээр:** Хагас жилийн байдлаар халамжийн нийтийг хамарсан ажлын төслийн хүрээнд 70 иргэнийг түр ажлын байраар хангаж оготно устгал, хог цэвэрлэгээний ажилд ажиллуулсан. Бүлгийн ногоо тариалалт 6 иргэн ажиллаж байна. Ахмад настны амралт сувилалд 12 ахмад настан амраад байна. Насны хишиг 188 ахмад настанд 15400,0 мян төгрөг олгоод байна. Хүнс тэжээлийн дэмжлэг 88 өрхийн 399 иргэнд 28632,0 мян төгрөг олгосон.

#### **Наран:**

**Нийгмийн халамж:** "Тохижилт" нийтийг хамарсан ажлыг 2020 оны 06 дугаа сарын 11-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж зорилтот өрхийн 10 иргэнийг түр ажлын байраар хангагдаж байна.

Иргэдийн нас, хүйс, боловсрол, үйлчилгээний төрлөөр дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 5 сарын 20-ны байдлаар 199 хүнд 30 чиглэлээр мэдээлэл өгөн ажилласан байна.

#### **Сүхбаатар:**

**Төрийн удирдлага:** 06.01-ний өдрөөс эхлэн ЗДТГазар нь Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд [www.operator.e-mongolia.mn](http://www.operator.e-mongolia.mn) үйлчилгээний мэдээллийн системийг ашиглан төрийн үйлчилгээний оператор ажиллуулж эхэлсэн бөгөөд 11 байгууллагын 54 төрлийн лавлагааг цахимаар гарган үйлчилж байна.

Газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх газрын зурагт тусгах, урьд өмнө нь тодруулан тогтоосон газар зүйн нэрээ хайрлан хамгаалах, үнэн зөв монгол нэрээр газар нутгаа нэрлэх, түүнийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлийг сумын Засаг даргын 2020.06.15-ны өдрийн А/95 тоот захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.

**Хөдөө аж ахуй, байгаль орчин, хөрөнгө оруулалтын чиглэлээр:** Бурхан багшийн Их дүйчин өдрөөр "НЭГ ӨРХӨӨС НЭГ ИРГЭН НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНД" уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж сумын эргэн тойрон дахь эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэсэн бөгөөд уг аянд нийт 150 гаруй иргэн хамрагдсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Цагдаагийн хэсгийг авто машинаар хангах ажил хийгдсэн ба ОНХСангийн 9.8 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон.

Аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг 05.25-31-ний хооронд амжилттай зохион байгуулсан ба хагас жилийн мал тооллогод 139 өрх түүврээр сонгогдож ирсэн бөгөөд эдгээр өрхийн нийт 105697 толгой малыг тоолж цахим санд шивсэн. Үүнээс тэмээ 415, адуу 9439, үхэр 7003, хонь 59664, ямаа 29176 тус тус тоологдсон.

Мөн аймаг, сумын Засаг даргын захирамжийн дагуу оготно устгах ажлын хэсгийг томилсон. Сумын Засаг дарга, аймгийн ХХААГазрын даргатай байгуулсан гэрээний дагуу тус суманд энгийн механик аргаар үлийн цагаан огтоно устгах ажлын хүрээнд хувиарлагдан ирсэн 11,7 сая төгрөгний санхүүжилтийн хүрээнд тус сумын 3, 4, 5-р багийн нутгуудад нийт 8000 га талбайг 10 малчны бүлгийн 75 хүн хүч, 25 авто машин, 5 мотоцикл бусад техник хэрэгслийг дайчлан ажилласан бөгөөд тус ажлыг 82 хувьтай хийж гүйцэтгэн тайлан мэдээг аймгийн ХХААГазар болон МХГ-т хүргүүлсэн.

**Түвшинширээ:** 2020 оны 06 сарын 24-ний өдөр хүчтэй бороо, мөндөр орсны улмаас Үнэгд болон Дэлгэрхаан багийн нутагт нийт 23 өрхийн 3048 толгой мал үрэгдэж 1 айлын 5 ханатай гэр үеэрт урсаж сүйдсэн байна. Одоогоор 14 хүний бүрэлдэхүүнтэй үхсэн малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөрт 5 иргэний төсөл ирсэн ба үүнээс 4 иргэний гагнуур, хүнсний ногоо, мод үржүүлэг, гар урлал зэрэг төсөл дэмжигдсэн.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гарааны бизнесийн сургалтад сумаас 1 бүлэг оролцон сургалтад хамруулсан.

ХЭДС-аас 2018-2019 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн эргэн төлөлт хийгээгүй иргэдтэй уулзаж цаг хугацаандаа хийхийг шаардан хийлгэж байна. 6-р сарын байдлаар 2019 оны малжуулах төсөлд хамрагдсан 5 өрхөөр хуваарийн дагуу 5,750,000 төгрөгийг бүрэн хийлгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн дагуу сумын ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэхээр Түвшинширээ сумын "Хамтын хүч" нэртэй 5 иргэний бүрэлдэхүүнтэй баг байгуулагдаж, ХЭДС-аас 5,0 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг багийн ахлагчид хүлээлгэн өглөө.

#### **Түмэнцогт:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Засаг даргын 2020 оны А/60 дугаар захирамжаар Газар зүйн нэрийн салбар зөвлөлийг байгуулж, газар зүйн нэрийн жагсаалт зохиох, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, нэрийг зөв бичих, шинээр өгсөн нэр болон нэрийн өөрчлөлтийн бүртгэл хөтлөх, газрын зурагт тусгах, урьд өмнө нь тодруулан тогтоосон газар зүйн нэрээ хайрлан хамгаалах, үнэн зөв монгол нэрээр газар нутгаа нэрлэх, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах зэрэг үүргийг хүлээн ажлаа эхлүүлээд байна.

Covid-19 шинэ төрлийн вирусын халдвараас урьдчилан сэргийлэх хүрээнд ААНэгж, байгууллага, ТББ, иргэн хамтран Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж, чиглэл, зааврийг тухай бүр сурталчилан, УИХурлын сонгуулиар өөрийгөө болон гэр бүлээ цар тахлаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар онлайн мэдээ, мэдээллүүдийг түгээж нийт 7021 ширхэг гарын авлага тарааж, цахимаар 350 төрлийн мэдээлэл хийсэн.

**Хөдөө аж ахуй:** Хагас жилийн малын түүвэр судалгаанд 76 өрх, 1 аж ахуйн нэгж хамрагдан тооллогын хийж явцын мэдээг 2 хоног тутам мэдээлэн 10 хоногийн хуагцаанд хянаж шалган програмд шивж илтгэх хуудас тайлбарын хамт статистикийн газарт хүрүүлж ажилласан.

**Байгаль орчин:** НҮБХХ, БОАЖЯ, УУХҮЯ, ХҮЭК, МХЕГ, ЦЕГ, МБОИЗ, Сүхбаатар аймгийн БОАЖГазар, тус сумын БОХУБайцаагч нарын хамтарсан баг "Говьмастер" ХХК-д уул уурхайн төслүүдэд хамтын оролцоотой байгаль орчны мониторинг хийх, зөвлөн туслах, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр ажилласан. Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус сумын Лхүмбэ багийн нутаг дэвсгэрт сэг зэм булж устгах ажлыг "Говьмастер" ХХК-аар хийлгэж, 5 цэгт 300 гаруй сэг зэм булж устгасан.

**Боловсрол:** ЭЕШалгалттай хичээлийн багш нар өөрийн бэлтгэж байгаа суралцагчдад өөрийн боломж нөхцлийг харж давтлага өгч ажиллаж байна. Математикийн хичээлээр зөвлөх багш Ганболдыг урьж 2 цагийн давтлага авч суралцагчдыг хамрууллаа.

Суралцагчдын зуны амралтын гэрийн даалгавар өгч нийт 523 суралцагчийн эцэг эх асран хамгаалагчдад хүргээд байна.

"Хүүхдийн аюулгүй байдлыг хангах"сэдвийн хүрээнд Үеэр усны аюулаас сэргийлье, Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд та бидний оролцоо чухал, Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, Эцэг эх асран хамгаалагчдад зөвлөмж гэсэн 13 төрлийн зөвлөмжийг 523 суралцагчийн эцэг эхэд 100 хувь хүргэж ажилласан.

Хурдан морь унаач хүүхэд, мотоцикл зөвшөөрөлгүй унаж байгаа суралцагчдын судалгааг гаргаж, 4 удаагийн зөвлөмжийг 98 эцэг эхэд хүргэж, мөн суралцагчдын амралтаар 4 удаа хамтарсан багаар осол гэмтлээс урьдчилан сэргийлэх Зөвлөмжийг 210 эцэг эхэд хүргэсэн.

#### **Эрдэнэцагаан:**

Сумын хэмжээнд үер усны аюулт үзэгдэл болж, айл өрх мал сүрэг өртсөн ба гамшигт нэрвэгдсэн иргэдийг хамгаалах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ажлыг багийн засаг дарга нар, холбогдох мэргэжилтэнгүүд, гал унтраах 47 дугаар ангийн төрийн албан хаагчид зохион байгуулж ажиллалаа.

**Хууль эрх зүйн салбарын чиглэлээр:** Нийт 21 хуулийн хүрээнд иргэд болон төрийн албан хаагчдад хууль сурталчилгаа, сургалт зохион байгуулж дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- ЗДТГ, Цагдаагийн Тасаг, Байгууллагын дарга эрхлэгч нар хамтран Тусгай зөвшрөөрөлтэй 28-н ААН-д 6 удаа бүлэг болон гарч ухуулга сурталчилгаа, зөвлөмж заавар захирамж мэдээлэл хүргэж ажилласан.
- Хээрийн түймэр, Хог хаягдал, Халдварт болон халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 39 бүлэг 2 удаа гарч давхардсан тоогоор 830 өрхөд, цагдаагийн тасаг 200 гарын авлага материал,
- Сумын цагдаагийн тасагтай хамтран Хилийн 0146-р ангийн Цэргийн албан 125 албан хаагчдад 1 удаа сургалт хийсэн,
- Хүн ам зүй нийгмийн хамгааллын мэргэжилтэн байгууллага иргэдэд чиглэсэн ухуулга сурталчилгааг Цахимаар 5 удаа нэвтэрүүлж бусад холбогдох мэдээллийг 15 удаа хуваалцаж ажилласан,
- 8 байгууллагын 17 албан хаагчдад Шилэн дансны мэдээлэл хийх зөвлөмж, байгууллагын Дотоод Хяналт Шалгалтын зөвлөлийн эрх үүргийн тухай сумын санхүүгийн албатай хамтран сургалт зохион байгуулсан.
- МАА-н генетик нөөцийн тухай хуулиар Малчин 13 өрхөд ангилалт хийж 280 өрх энэ чиглэлд хамаарах 5 ААН-д заавар зөвлөмж өгч ажилласан.
- Сумын төвд хүнсний худалдаа эрхлэдэг 36 үйлчилгээний цэг дэлгүүр, 3 хоол үйлдвэрлэлийн газарт гарын авлага материал 450 ш, Сав баглаа боодлыг стандартын шаардлага хангасан байх ёстойг сурталчилж 25ш усны савыг иргэдэд олгож, ажилласан ба халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бүлэгт хуваагдаж дэлгүүр хоол, махны худалдааны цэгт 65 материалыг хүргэж ажилласан.
- Хөдөлмөр халамж хариуцсан мэргэжилтэн 27 иргэн 15 ААНБ-д гарын авлага материал олгож цахимаар мэдээлэлийг хуваалцаж ажилласан.
- Сумын нийгмийн даатгалыг байцаагч нар хөдөөгийн 1, 4, 6 дугаар багуудад өрх бүрт очиж үйлчилсэн 345 иргэн, сумын төвд ажлын байранд ирж үйлчлүүлсэн 185, бүгд 530 иргэнд хуулийг сурталчилсан. Үүний үр дүнд Тэтгэвэр тогтоолгох материалаа бүрдүүлж буй 21 иргэн, Материалаа бүрдүүлээд хүсэлтээ гаргасан 4 иргэн байна.
- Гурав хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн сайн дурын даатгалыг 50 хувийг төр хариуцна гэсэн өөрчлөлтийг 130 иргэнд сурталчилж зөвөлгөө өгсний үр дүнд 63 эх хамрагдаад байна.

**Соёлын төв:** Хүн ам зүйн мэргэжилтэнтэй хамтран угийн бичиг хөтөлдөг өрхийн судалгааг гарган, **Угийн бичиг- Удмын бахархал** уралдааныг зарлаад байна. Интернэт цахим сүлжээнд Сүхбаатар аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн газраас зохион байгуулж байгаа угийн бичгийн сургалтын цахим бичлэг, угийн бичгийн талаар мэдээ мэдээлэл, угийн бичгийн уриалгыг тус тус олон нийтэд түгээн хүргэн ажилласан ба хандаж үзэж сонирхсон хүмүүсийн тоо 4080 болсон байна.

2020 оны хагас жилийн байдлаар нийтийн номын сан нь цахим орчинд өөрийн үйл ажиллагааг байнга сурталчилан, мөн соёл олон түмний арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа. Энэ хугацаанд уншигчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс интернэтээс сонирхолтой өгүүллэг тууж, сонсдог ном, монголын нууц товчоо зэргийг цувралаар татан оруулж толилуулахын зэрэгцээ 48 хүнд нийт 113 ширхэг ном хэвлэлийг зөөврөөр олгосон байна.

Соёлын төвийн дээврийн засварын ажлыг “Ёст бэйс” компани 30.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарч ажлыг эхлүүлээд байна.

**Сургууль:** Сургуулийн орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, химийн кабинетийг 31.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар багш хөгжлийн төвийг нийт 14558500₮ өртөг бүхий ширээ сандал тоног төхөөрөмжөөр хангаад байна.

960 хүүхдийн сургуулийн барилга 4 дүгээр улиралд барьж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Багш хөгжлийн төвийг шаардлагтай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлж

**Эрүүл мэндийн төв:** Эх хүүхдэд ээлтэй байгууллага шалгаруулах болзолт уралдаан зарлаж дүгнэсэн ба ЕБС, Сувд эмийн сан, Сумын эрүүл мэндийн төвүүдэд эх хүүхдийн өрөө, живх солих өрөө, хүүхэд саатуулах тоглоомын өрөөнүүдийг тохижуулж 56,000 төгрөгний тоглоом байрлуулсан.

Эх хүүхдийн өрөөг шинээр бий болгон тохижуулж эмч, эмнэлгийн ажилчдын өөрсдийн сэтгэлийн дэм, хуримтлалаас нийт 1,980,000 төгрөгийг зарцуулсан.